

## **АМЬТНЫ ХҮРЭЭЛЭН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь Орхон аймгийн нутаг дэвсгэрт амьтны хүрээлэн ажиллуулах иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, эрх, үүрэг, үйл ажиллагаа, тавигдах шаардлагыг тодорхойлох зорилготой. Мөн амьтныг олон нийтэд үзүүлэн таниулах, хамгаалах, өсгөн үржүүлэх үйл ажиллагааг зохицуулж, үйлчлүүлэгч болон амьтны эрхийг хамгаалах, хяналт тавих харилцааг зохион байгуулна.

1.2. Орхон аймгийн нутаг дэвсгэрт амьтны хүрээлэн ажиллуулах үйл ажиллагааг бүртгэх, хяналт тавих, амьтны бүртгэл хөтлөх, тайлагнах ажлыг Байгаль орчны газар зохион байгуулна.

1.3. “Зөвшөөрлийн тухай хууль”-ийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1–1.31-д заасан, нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах, амьтныг сэргээн нутагшуулах, амьтан болон тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, ан амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох, байгаль орчны аудит хийх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, генетикийн нөөц болон түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, озон задалдаг болон дэлхийн дулааралд нөлөөлөх бодисыг импортлох, худалдах, ашиглах, тэдгээрийг дахин боловсруулах, системээс юүлэх, цэвэрлэх, дахин цэнэглэх, тоног төхөөрөмж угсрах, засвар үйлчилгээ хийх, устгах, ойн болон усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, харь амьтныг нутагшуулах, өсгөж үржүүлэх, химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, үйлдвэрлэх, ашиглах, ховор амьд амьтны цуглуулга хийх, ховор ургамлыг эмийн зориулалтаар ашиглах, хувиргасан амьд организмыг хил дамнуулан тээвэрлэх, экспортлох, импортлох, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах, ургамлыг гадаад улсад гаргах, олон улсын конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох, газар эзэмших, ашиглах, энгийн болон үйлдвэрлэлийн зориулалттай хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах, тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах, хоногт 50-аас дээш шоометр ус ашиглах, ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, ойгоос мод бэлтгэх, газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх зэрэг үйл ажиллагаанд энэ журам хамаарахгүй.”

### **Хоёр. Амьтны хүрээлэн ажиллуулах хүсэлт гаргах, бүртгүүлэх**

2.1. Амьтны хүрээлэн ажиллуулах хүсэлтэй иргэн, хуулийн этгээд Байгаль орчны газарт хүсэлт гарган бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ.

2.2. Хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж хавсаргана:

- Амьтны хүрээлэнгийн нэр, байршил;
- Ан амьтны мэргэжлийн байгууллагын гэрчилгээ;
- Техникийн үзүүлэлт, төлөвлөгөө;
- Амьтдын бүртгэлийн жагсаалт;
- Мэргэжлийн ажилтнуудын мэдээлэл;
- Амьтдын амьдрах орчныг бүрдүүлэх төлөвлөгөө;
- Аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө;
- Халдварт өвчин, зоонозоос сэргийлэх төлөвлөгөө;
- Хүрээлэнг хаах үед амьтдыг шилжүүлэх, хамгаалах төлөвлөгөө;
- Галын аюулгүй байдлын дүгнэлт;

- Хог тээврийн гэрээ;
- Байгаль орчны үнэлгээ, менежментийн төлөвлөгөө;
- Хууль тогтоомжийн дагуу шаардагдах бусад зөвшөөрөл, төлбөр, хураамж.

2.3. Байгаль орчны газар хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 ажлын өдрийн дотор шалгаж, шаардлага хангасан тохиолдолд бүртгэж үйл ажиллагаа явуулах эрх олгоно.

### **Гурав. Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлага**

3.1. Амьтны хүрээлэн нь холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагаас гадна дараах нөхцөлийг хангана:

- Ан амьтны мэргэжлийн байгууллагын эрхтэй байх;
- Хашаа, байр, барилга байгууламжийг стандартын дагуу тохижуулсан байх;
- Мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжтэй байх;
- Эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээний хэсэгтэй байх;
- Хаяг, тэмдэг, тэмдэглэгээг зөв байршуулсан байх;
- Тусгай хэрэгцээтэй иргэдэд зориулсан тохижилттой байх;
- Халаалтыг агаар бохирдуулахгүйгээр шийдсэн байх;
- Хяналтын камертай байх;
- Үйлчилгээний талаарх мэдээлэл, анхааруулгыг байршуулсан байх;
- Ажиллах цагийн хуваарийг ил тод мэдээлсэн байх;
- Эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдсан байх

### **Дөрөв. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үйл ажиллагаа**

4.1. Амьтны хүрээлэн ажиллуулж буй иргэн, хуулийн этгээд дараах эрхтэй:

- Амьтныг хуульд нийцүүлэн шилжүүлэн авах, хамгаалах;
- Амьтанд болон эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргах;
- Согтууруулах ундаа хэрэглэсэн болон харгалзах хүнгүй бага насны хүүхдэд үйлчлэхээс татгалзах.

4.2. Иргэн, хуулийн этгээд дараах үйл ажиллагаа хэрэгжүүлнэ:

- Амьтдыг тэжээл, тохирсон орчноор хангах;
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тав тухыг хангах;
- Амьтдыг урьдчилан сэргийлэх тарилгад хамруулах, ариутгал хийх, гэрээт малын эмчтэй байх;
- Өвдсөн амьтанд анхан шатны тусламж үзүүлж, мэргэжлийн байгууллагад мэдэгдэх;
- Үхсэн амьтныг мэргэжлийн байгууллагатай хамтран устгуулах;
- Ажилтнуудаа мэргэжлийн сургалтад тогтмол хамруулах;
- Галын болон хог хаягдлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагаагаа эрсдлээс даатгуулсан байх;
- Мэргэжлийн байгууллагын үүрэг чиглэлийг биелүүлэх;
- Халдварт өвчин, хорио цээрийн үед үйл ажиллагаа явуулахгүй байх.

### **Тав. Аюулгүй байдлын удирдлага**

5.1. Үйлчлүүлэгч, ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2. Амьтан хашаанаас гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авч, холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

### **Зургаа. Амьтны эрхийг хамгаалах**

6.1. Амьтны хүрээлэн болон ажилтан нь дараах үйл ажиллагааг хориглоно:

- Амьтныг зодох, тамлах, хаях, төөрүүлэх;
- Амьтныг тулалдуулах, хүчирхийллийн шинжтэй тэмцээн зохион байгуулах;
- Хэт их эм, буруу хэрэгсэл ашиглах;
- Хоол, усаар дутаах;
- Туршилт хийх, зан авирыг хэрцгий болгох.

6.2. Амьтанд шаардлагатай хоол хүнс, эмчилгээ, ус, орчныг бүрэн хангана.

### **Долоо. Түр хаах, үйл ажиллагааг зогсоох, бүртгэлээс хасах**

7.1. Түр ажиллах боломжгүй болсон тохиолдолд бүртгүүлсэн байгууллага болон олон нийтэд мэдэгдэнэ.

7.2. Үйл ажиллагаагаа бүрэн зогсоох бол бүртгүүлсэн байгууллагад мэдэгдэж, бүртгэлээс хасуулна.

7.3. Зөрчил илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллага хугацаатай үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулах эрхтэй.

7.4. Зөрчлийг арилгуулаагүй, шаардлага хангаагүй нь тогтоогдсон бол үйл ажиллагааг зогсоож, бүртгэлээс хасна.

7.5. Үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд амьтдыг шилжүүлэн байрлуулах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

### **Найм. Хариуцлага**

8.1. Амьтныг зохих ёсоор хамгаалаагүйгээс хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирвал тухайн байгууллага Иргэний хуулийн дагуу хариуцна.

8.2. Журам зөрчсөн тохиолдолд хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.